

Суралцагчдадаа итгэх

Дараах мэдэгдлийг уншаад, суралцагчдынхаа сайн мэдээний сургаал, зарчмуудыг судалж, зааж, хэрэгжүүлэх ур чадварт итгэж болох шалтгааныг ойлгоход тань туслах үгс болон хэллэгүүдийн доогуур зур.

1. Бошиглогч Иосеф Смит:

“Дэлхийд Бурханы илгээсэн аливаа оюун ухаан болон сүнснүүд өргөжин тэлэх чадвартай юм” хэмээн заасан байдаг (Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит [2007], 238).

2. Тэргүүн Зөвлөлийн ерөнхийлөгч Ж.Рүбен Кларк (1871–1961):

“Сүмийн өсвөр үеийнхэн сүнслэг зүйлсээр өлсөж цангаж байна. Тэд сайн мэдээг шулуухан, ямар ч нэмэлт хачиргүйгээр сурахад үнэхээр бэлэн байна. Тэд бол . . . эргэлзэгч биш харин эрэлхийлэгчид, тэд бол үнэний эрэлчид. . . .

“Та эдгээр суралцагчийг тан руу ирэх үед, тэдэнд зөв сүнслэг хоол өгөх юм бол тун удахгүй хүрэх боловсорсон байдал руу сүнслэгээр тэмүүлж байдаг. Тэд дэлхийн мэдэхгүй сүнслэг мэдлэг болон туршлагыг боловсруулан тан руу ирдэг” гэж хэлжээ (*The Charted Course of the Church in Education*, rev. ed. [1994], 3, 5–6).

3. Тэргүүн Зөвлөлийн ерөнхийлөгч Хэнри Б.Айринг заахдаа:

“Хэрэв та [суралцагчидтайгаа] эрэлч хайгуулч мэтээр харьцвал тэд таныг тэдэнд хайртай гэдгийг мэдрэх болно хэмээн би та нарт амлаж байна. Энэ нь тэдний дотор байгаа найдварыг сэрээж, тэд илүү зөөлөн зүрх сэтгэлтэй болж болно. Энэ нь тухай бүрд тохиолдохгүй мөн удаан үргэлжлэхгүй байж болно. Гэвч ойр ойрхон тохиолдож, заримдаа удаан үргэлжилж болно. Тэгээд тэд бүгдээрээ ядаж л Бурханы хүүхдүүдийн хувьд өвлөж авсан хамгийн сайн сайхан бүхэнд итгэж байсныг тань санах болно” гэжээ (“And Thus We See’: Helping a Student in a Moment of Doubt” [Сүмийн Боловсролын Системийн шашны багш нарт хандаж хэлсэн үгс, 1993 оны 2-р сарын 5], 5; si.lds.org).

4. Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) заахдаа:

“Их Эзэн энэ хэцүү цаг үед өөрийн ажлыг урагшлуулахад туслуулахаар нөөцөлж байсан агуу хүчирхэг сүнснүүдээ илгээж байна. Эдгээр сүнсийг хийх ёстой ажлаа хийхэд нь сургаж, бэлдэх хэрэгтэй” хэмээсэн (“Men of Example” [Сүмийн Боловсролын Системийн шашны багш нарт хандаж хэлсэн үгс, 1975 оны 9-р сарын 12], 5; si.lds.org).

5. Тэргүүн Зөвлөлийн ерөнхийлөгч Дийтр Ф. Угдорф:

“Манай залуучууд Аврагчид итгэж, Түүний тухай илүү ихийг мэдэхийг хүсдэг” хэмээн заасан (“A Teacher of God’s Children” [Сүмийн Боловсролын Системийн шашны багш нарт хандаж хэлсэн үгс, 2011 оны 1-р сарын 28], 6, si.lds.org).

6. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн:

“Тэргүүн Зөвлөлд үйлчилж байсан ерөнхийлөгч Жорж К.Канноны (1827–1901) хэлсэн: ‘Бурхан дэлхийтэй мөн хилэнцэт нэгний ил ба далд бүхий л хүчтэй нүүр тулж, сайн мэдээг тунхаглаж, үнэнийг сахин, ямар ч үр дагавраас үл айн, Бурханы Сионыг байгуулан барих зоригтой, шийдэмгий сүнснүүдийг энэ эрин үед зориулан нөөцөлсөн байсан. Тэр хэзээ ч түлхэн унагах боломжгүй Сионы суурийг тавиулахаар, зөв шударга болох, Бурханыг эрхэмлэх, Түүнийг бүр дэндүү ихээр эрхэмлэж, бүх нөхцөл байдалд Түүнд дуулгавартай байх тэдгээр үрийг өсгөн үржүүлэх сүнснүүдийг энэ үед илгээсэн юм’ хэмээх үгсэд би дуртай [*Deseret News*, 1866 оны тавдугаар сарын 31, 203].

Танай ангийн залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд бол энэхүү сүнснүүд юм. Тэд бол ирээдүйн найдвар” хэмээн гэрчилсэн (“A Classroom of Faith, Hope, and Charity” [Ерөнхий эрх мэдэлтэнтэй хамт нэгэн үдэш, 2014 оны 2-р сарын 28], lds.org/broadcasts).



7. Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994):
“Бурхан та нарыг Их Эзэний Хоёр дахь ирэлтийн өмнөх эцсийн өдрүүдэд ирүүлэхээр бараг зургаан мянган жилийн турш нөөцлөн байсан. . . . Бурхан Хаант улсыг уухайлан, дэмжин туслах хамгийн хүчирхэг хүүхдүүдийнхээ заримыг эцсийн өдрүүдэд зориулан хадгалж байгаа. Та нар тэндээс ирсэн бөгөөд Бурхантайгаа уулзахаар бэлтгэгдсэн байх ёстой үеийнхэн билээ. . . . Үүний талаар алдаа бүү гарга—та бүхэн сонгогдсон үеийнхэн юм. . . . [Та нар] урьдчилан томилогдсон үүрэг, эцсийн өдрүүддээ үнэнч байх уу?” гэжээ (“In His Steps” [Бригам Янгийн Их Сургуулийн галын дэргэдэх цугларалт, 1979 оны 3-р сарын 4], 1, speeches.byu.edu).
8. Тэргүүн Зөвлөлийн ерөнхийлөгч Хэнри Б.Айринг тайлбарлахдаа:
“[Суралцагчид маань] Сүнсний зүйлсийн төлөө өлсөх болно. Сүнс тэдэнд үнэнийг батлах үед танин мэдэх болно. Тэд Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний үндсэн үнэний тухай бидний гэрчлэлийн хүчийг мэдэрснээр гэрчлэл нь улам гүнзгийрэхийг хүлээж ядан байх болно” гэжээ (“The Lord Will Multiply the Harvest” [Сүмийн Боловсролын Системийн шашны багш нарт хандаж хэлсэн үгс, 1998 оны 2-р сарын 6], 2, si.lds.org).

